



**ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА**

2018 оны 02 дугаар сарын 13

№ 01/64 ДУА - 2018/02/СТА - 7413 Мандалговь хот

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1-д тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд Дундговь аймаг дахь Төрийн аудитын газрын 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу Дундговь аймгийн Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийх явцад цалингийн сангаас оны тэргүүний ажилтнуудад 2,765,491.0 /Хоёр сая долоон зуун жаран таван мянга дөрвөн зуун ерин нэгэн/ төгрөгийн шагнал олгосон.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-д /Төсвийг үр ашигтай хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах/ мөн хуулийн 16.5.5-т /Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах/, Сангийн сайдын 2014 оны 5 дугаар тушаалаар батлагдсан "Эдийн засгийн ангилал батлах тухай"-д /Ажиллагсдын цалин, хөлс болон хуулиар нийгмийн даатгалын шимтгэл бодогдох нэмэгдэл урамшууллын зардлууд энэ ангилалд хамаарна. Эдгээр зардлуудыг бүлгийн дүнгээр хянана/ заасныг тус тус зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 15.1.12-т /Аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх, хууль тогтоомж, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон бусад шийдвэрийг боловсронгуй болгох саналыг холбогдох байгууллагад тавих/, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2014 оны 138 дугаар тушаалаар батлагдсан Төрийн аудитын байгууллагын ажилтны нийтлэг эрх, үүргийн тухай дүрмийн 2.2.3-т /Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийг хэрэгжүүлэх хүрээнд төрийн аудитын байгууллагын ахлах аудитор, ахлах шинжээч, аудитор, шинжээч нь аудитын явцад илэрсэн төлбөрийг барагдуулах, зөрчлийг арилгуулах зорилгоор төлбөрийн акт, албан шаардлага өгөх/, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны 09 дүгээр сарын 09-ны өдрийн А/95 дугаар тушаалаар баталсан Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журмын 4.1.3-д /Төсвийн хөрөнгийг үр ашиггүй, зориулалт бусаар батлагдсан хэмжээнээс хэтрүүлэн зарцуулж, төсвийн тухай хуулийн холбогдох зүйл заалтыг зөрчсөн/ заасныг тус тус үндэслэн ШААРДАХ НЬ:

1. Төсвийг үр ашигтай, эдийн засгийн ангиллыг баримталж, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллах,
2. Албан шаардлагыг хэрэгжүүлж, биелэлтийг аймгийн Төрийн аудитын газарт 2018 оны 03 дугаар сарын 25-ны дотор албан ёсоор ирүүлэхийг Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн төсвийн шууд захирагч Ж.Эрхэмбаяр, нягтлан бодогч Б.Рэнцэн нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГЫГ

ӨГСӨН¹:

АУДИТОР  Т.ОЮУН-ЭРДЭНЭ

ЗӨВШӨӨРСӨН:

ДАРГА  Ж.ЭРХЭМБАЯР

НЯГТЛАН БОДОГЧ  Б.РЭНЦЭН

¹ Акт, албан шаардлагын биелэлт хангаагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.